



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 11 сарын 24 өдөр


Дугаар А/325

Өмнөдэлгэр сум


**Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх
вакцинжуулалтын ажлыг зохион байгуулах тухай**

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6, 9.7, 9.8, 9.9 дэх заалт, аймгийн Засаг даргын 2025 оны 11 дүгээр сарын 07-ны өдрийн А/612 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор сумын хэмжээний бүх үхэр, тугал, гахайг зааврын дагуу дархлаажуулах ажлыг төлөвлөгөөт хугацаанд зохион байгуулсугай.
2. Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх тарилгад хамрагдах малын тоог хавсралтаар баталсугай.
3. Дархлаажуулалтын ажилд онцгой ач холбогдол өгч, малчдад зар хүргэх, тарилгын хашаа хоолойг бэлтгүүлж, тарилгын ажилд хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.
4. Тарилгын явц, гүйцэтгэлд хяналт тавьж, мэргэжил арга зүйн зөвлөгөөгөөр хангаж, тарилгын дүн болон санхүүгийн баримт материалыг бүрдүүлэн аймгийн Мал эмнэлгийн газарт хүргүүлэхийг Мал эмнэлгийн тасагт үүрэг болгосугай.



Р.ЭНХТӨР



сумын Засаг даргын 2025 оны
..... дүгээр сарын-ны өдрийн
А/325 дугаар захирамжийн хавсралт

ШҮЛХИЙ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ 2025 ОНЫ НАМРЫН ДАРХЛААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ
МАЛЫН ТОО, ВАКЦИНЫ ХУВААРЬ

№	Аж ахуйн нэгжийн нэр	Хамруулах мал, амьтан /толгой/			Шаардлагатай вакцин		Хайрцаг	Шил
		Үхэр	Тугал	Гахай	Нийт	Тун	Литр	
1	Юмт гэгээ	21176	7372	67	28615	28600	57.2	12
2	Хичээнгүй экспресс	4700	1600		6300	6300	12.6	46
3	Мэргэн жонон	8900	3167	33	12100	12100	24.2	2
4	Өвөр Зотлог	2500	800		3300	3300	6.6	66
5	Хэйлти анимал стронг	6800	2300		9100	9100	18.2	22
Дүн		44076	15239	100	59415	59400	118.8	148